БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 06 сарын 12 өдөр  Дугаар 7/31  Номгон

"Чандмань-Баянхонгор" ХХК-ний
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
томилох батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12, 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, Компанийн тухай хуулийн 62.1.7, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 5/03 дугаар тогтоолоор баталсан "Чандмань-Баянхонгор" ХХК-ийн дүрмийн 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Авлигатай тэмцэх газрын 2025 оны 05 дугаар сарын 05/9172 тоот албан бичгийн дагуу "Чандмань-Баянхонгор" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн батлсугай.

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 124, 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 39, 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 128 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Э.ЭНХБАТ

642401081

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн
7/31 дүгээр тогтоолын хавсралт

"ЧАНДМАНЬ-БАЯНХОНГОР" ХХК-НИЙ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ШИНЭЧИЛСЭН БҮРЭЛДЭХҮҮН

| № | Овог, нэр | Албан тушаал |
|---|---|---|
| 1 | Дагвын Юндэнбазар | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн |
| 2 | Готовын Хоролсүрэн | Иргэн |
| 3 | Дондовын Мөнхжаргал | Иргэн |
| 4 | Хавчуурын Энхбаяр | Иргэн |
| 5 | Лхагвасүрэнгийн Батбаяр | Иргэн |
| 6 | Наянчулууны Сундуйрагчаа | Иргэн |
| 7 | Бямбаагийн Цолмон | Иргэн |
| 8 | Жадамбын Мөнхсоёл | Иргэн |
| 9 | Сайнхүүгийн Гантуяа | Иргэн |

____________o0o____________